



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/185/СТА-ТШЗ

Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..	Error! Bookmark not defined.



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН 15 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ П.АДЪЯА ТАНАА

Ауд.02.27 № 1/185

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020126

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч П.Адъяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 22-ноос 2020 оны 02 дугаар сарын 26-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэг нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэг нь тайлант хугацаанд Сургуулийн өмнөх боловсрол олгох эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сургалтын үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлэх тохилог иж бүрэн орчин бүрдүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх
- Сургалтын чанарыг сайжруулах, сурлагын амжилт, чанараар аймгийн хэмжээнд тэргүүлэх

- Хүүхэд бүрийн авьяас, сонирхлыг хөгжүүлэх, зөв хүн төлөвшүүлэх гэсэн стратегийн зорилтыг хангах

- Хүний нөөц чадавхыг хөгжүүлэх стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх

- Хамтын ажиллагааг өргөжүүлэх гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ

- Цэцэрлэгийн менежментийг боловсронгуй болгох гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг чиглэсэн зорилтууд дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Аcolous программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1041214.5 мянган төгрөгөөс 1,0 хувиар тооцон 10412.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10412.1 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь, материаллаг байдлыг тооцох хувийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20448,6 мянган төгрөгөөр буюу 2,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, өглөг, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0,0	0,0	0
Авлага			
Дуусаагүй үйлдвэрлэл	758400,0		-758400,0
Бараа материал	21752,9	27872,8	6119,9
Үндсэн хөрөнгө	52381,5	833161,6	780780,1
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-8625,0	-16676,4	-8051,4
Нийт хөрөнгө	823909,4	844358,0	20448,6
Өр төлбөр	0	1401,8	1401,8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	823909,4	842956,2	19046,8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	823909,4	844358,0	20448,6

Бараа материалын дансны үлдэгдэл 6119,9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 53337,5 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 47217,6 мянган төгрөгийн зарцуулалт гарснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй нөөцөлсөн бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 780780,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 4173,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч,

барааны нөөцөөр бүртгэлтэй байсан дуусаагүй үйлдвэрлэлийн 759400,0 мянган төгрөгийн барилга ашиглалтадп орсныг шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталсан үндсэн хөрөнгө байхгүй.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 842956,2 мянган төгрөг болж 19046,8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүн өссөнтэй холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 296687,6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 249293,1 мянган төгрөгийг ТЗШ-ээс, 47394,5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл ТЗШ-ийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтийг батлагдсан хэмжээнд авч, 296304,5 мянган төгрөгийг зарцуулан 383,7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 296304,5 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Тайлант онд НДХ-ээс ЖА-ны листний мөнгө 1280,8 мянган төгрөг нэмэлт санхүүжилтээр орсноос өөр эх үүсвэр байхгүй байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 28 эрсдэл тодорхойлж, гүйцэтгэлийн шатанд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2701,8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1401,8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах заалт бүхий зөвлөмж өгч, 1300,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны 12-р сарын 18-ны 45 тоот тушаалаар ажилтнуудад түлш хоолны хөнгөлөлтөд 1631,0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэл

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, төсөвт хохирол учруулах

Шийдвэрлэсэн нь:

Түлшний хөнгөлөлтөд ажиллагсдад олгосон мөнгөнөөс НДШ, ХХОАТ-ыг хассан дүн 1300,0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулах үүрэгтэй.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	3	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	32	4	
	Тухай бүр	8	96	55	41	
	Нийт	27	151	101	48	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1000,0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 заалт бүхий зөвлөмж өгснийг давтан шалгахад 100,0%-ийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 04-р сарын 26-ны өдөр ирүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Төсөв , гүйцэтгэлтэй холбоотой асуудал :

Илрүүлэлт

1. Цалингийн зардлыг анхан шатны баримтаас хөөн давтан тооцоолоход нягтлан бодогч татвар шимтгэлийн тооцоог тухай бүр хийгээгүйгээс оны эцэст ХХОАТ-ын 1401,8 мянган төгрөгийн өртэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэл

Батлагдсан төсвийг хэтрүүлэх, өр, авлага нэмэгдэх

Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагатай ХХОАТ-ын тооцоог улирал тутам хийж үлдэгдлийг баталгаажуулж байх, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүнгийн талаар төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>780,152,868.00</u>	<u>27,872,848.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	21,752,868.00	27,872,848.00
351	Түүхий эд материал	20,515,468.00	26,065,068.00
35110	Тусгай зориулалттай материал	20,478,268.00	26,042,368.00
35130	Эм боох материал	37,200.00	22,700.00
354	Хангамжийн материал	1,237,400.00	1,807,780.00
35410	Бичиг хэргийн материал	212,000.00	267,100.00
35420	Аж ахуйн материал	600,000.00	600,000.00
35460	Хүнсний материал	425,400.00	940,680.00
36	НӨӨЦИЙН БАРАА	758,400,000.00	00.00
36100	Барааны нөөц	758,400,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,756,520.08</u>	<u>816,485,163.59</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,756,520.08	816,485,163.59
392	Биет хөрөнгө	43,052,520.12	815,913,163.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	758,400,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,173,670.00	34,151,670.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,543,610.52	-8,646,161.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,327,887.50	39,729,879.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,905,426.86	-7,722,224.70
393	Биет бус хөрөнгө	703,999.96	571,999.93
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-176,000.04	-308,000.07
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>823,909,388.08</u>	<u>844,358,011.59</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>1,401,777.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,401,777.00
413	Өглөг	00.00	1,401,777.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,401,777.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>823,909,388.08</u>	<u>842,956,234.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	823,909,388.08	842,956,234.59
512	Хуримтлагдсан үр дүн	823,909,388.08	842,956,234.59
51210	Өмнөх үеийн үр дүн	823,909,388.08	823,909,388.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	19,046,846.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>823,909,388.08</u>	<u>844,358,011.59</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	996,484,370.80	1,060,261,391.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	779,163,958.00	763,573,791.91
120	Нийтлэг татварын бус орлого	779,163,958.00	763,573,791.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	779,163,958.00	763,573,791.91
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	779,163,958.00	763,573,791.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,365,512.80	47,394,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	211,954,900.00	249,293,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,606,713.80	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,606,713.80	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	47,394,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	47,394,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,758,799.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,758,799.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	209,985,811.76	282,814,545.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	209,985,811.76	282,814,545.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,230,263.96	282,347,159.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	123,600,614.00	166,989,648.00
210101	Үндсэн цалин	106,721,265.00	140,389,707.00
210102	Нэмэгдэл	7,165,200.00	10,049,700.00
210104	Урамшуулал	9,714,149.00	16,550,241.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,609,701.00	21,544,029.00
210201	Тэтгэврийн даатгал	14,609,701.00	14,997,029.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,636,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,309,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	327,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,273,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,643,976.00	33,649,473.00
210301	Гэрэл, цахилгаан	2,487,729.00	3,762,329.00
210302	Түлш, халаалт	14,037,647.00	25,876,848.00

**Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210303	Цэвэр, бохир ус	3,118,600.00	4,010,296.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,204,800.00	2,486,596.00
210401	Бичиг хэрэг	212,300.00	526,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	759,853.00	1,064,296.00
210404	Ном, хэвлэл	43,600.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	147,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,189,047.00	748,000.00
2105	Нормативт зардал	36,425,874.00	44,411,765.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	130,000.00	66,900.00
210502	Хоол, хүнс	36,295,874.00	44,046,865.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	298,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	122,400.00	4,455,000.00
210604	Урсгал засвар	122,400.00	4,455,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	105,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	105,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	430,900.00	654,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	430,900.00	404,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,191,998.96	8,051,348.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,191,998.96	8,051,348.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,755,547.80	467,386.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,138,599.00	84,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,758,799.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	379,800.00	84,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	355,027.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	355,027.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,616,948.80	28,059.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,616,948.80	28,059.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>786,498,559.04</u>	<u>777,446,846.51</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	758,400,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	758,400,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-758,400,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>786,498,559.04</u>	<u>19,046,846.51</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	217,320,412.79	297,968,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	217,320,412.79	297,968,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	211,954,899.99	249,293,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,606,713.80	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,606,713.80	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	47,394,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	47,394,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,758,799.00	1,280,800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,758,799.00	1,280,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	217,320,412.79	280,762,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,320,412.79	280,762,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	213,564,865.00	279,014,014.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,896,315.00	163,872,800.00
210101	Үндсэн цалин	108,016,966.00	137,272,859.00
210102	Нэмэгдэл	7,165,200.00	10,049,700.00
210104	Урамшуулал	9,714,149.00	16,550,241.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,314,000.00	23,259,100.00
210201	Тэтгэврийн даатгал	9,530,800.00	16,712,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	68,200.00	1,636,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	857,600.00	1,309,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	713,400.00	327,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,144,000.00	3,273,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,643,976.00	33,649,473.00
210301	Гэрэл, цахилгаан	2,184,977.00	3,762,329.00
210302	Түлш, халаалт	11,811,347.00	25,271,344.00
210303	Цэвэр, бохир ус	5,647,652.00	4,615,800.00

**Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2104	Хангамж, бараа материалын зардал	4,317,400.00	2,274,196.00
210401	Бичиг хэрэг	68,400.00	201,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	759,853.00	1,064,296.00
210404	Ном, хэвлэл	43,600.00	113,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	147,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,445,547.00	748,000.00
2105	Нормативт зардал	48,901,374.00	49,617,545.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,200.00	52,400.00
210502	Хоол, хүнс	36,721,274.00	44,562,145.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,142,900.00	5,003,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	122,400.00	4,572,000.00
210604	Урсгал засвар	122,400.00	4,572,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	105,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	105,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	430,900.00	654,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	430,900.00	404,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,938,500.00	1,009,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,938,500.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,009,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,755,547.79	1,748,186.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,138,599.00	1,365,100.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,758,799.00	1,280,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	379,800.00	84,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,616,948.79	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,616,948.79	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	355,027.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	355,027.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	28,059.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	28,059.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	17,206,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	17,206,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	17,206,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	17,206,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	17,206,200.00

Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	<u>-17,206,200.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	823,909,388.08	00.00	823,909,388.08
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	823,909,388.08	00.00	823,909,388.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	823,909,388.08	00.00	823,909,388.08
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	19,046,846.51	00.00	19,046,846.51
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	842,956,234.59	00.00	842,956,234.59

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

**Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,159,300.00	58,159,300.00	296,688,200.00	307,722,136.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,159,300.00	58,159,300.00	296,688,200.00	307,722,136.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,459,300.00	52,459,300.00	296,576,000.00	307,637,836.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,753,000.00	28,753,000.00	163,872,800.00	175,290,422.00
210101	Үндсэн цалин	25,634,600.00	25,634,600.00	137,400,800.00	148,690,481.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	12,917,300.00	10,049,700.00
210104	Урамшуулал	3,118,400.00	3,118,400.00	13,554,700.00	16,550,241.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,162,800.00	3,162,800.00	23,259,100.00	23,259,100.00
210201	Тэтгэврийн даатгал	3,162,800.00	3,162,800.00	16,712,100.00	16,712,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	1,636,700.00	1,636,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	1,309,500.00	1,309,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	327,300.00	327,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	3,273,500.00	3,273,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	750,000.00	750,000.00	34,005,100.00	33,649,473.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	00.00	2,709,100.00	3,762,329.00
210302	Түлш, халаалт	750,000.00	750,000.00	26,106,000.00	25,271,344.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	00.00	5,190,000.00	4,615,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,010,800.00	2,010,800.00	2,274,200.00	2,274,196.00
210401	Бичиг хэрэг	450,000.00	450,000.00	201,300.00	201,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,367,300.00	1,367,300.00	00.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	193,500.00	193,500.00	1,064,300.00	1,064,296.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	113,100.00	113,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	147,500.00	147,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	748,000.00	748,000.00
2105	Нормативт зардал	16,800,000.00	16,800,000.00	49,617,700.00	49,617,545.00

**Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00	52,400.00	52,400.00
210502	Хоол, хүнс	9,900,000.00	9,900,000.00	44,562,300.00	44,562,145.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,900,000.00	6,900,000.00	5,003,000.00	5,003,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	20,390,200.00	20,390,200.00
210602	Тавилга	00.00	00.00	6,828,200.00	6,828,200.00
210604	Урсгал засвар	00.00	00.00	13,562,000.00	13,562,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	105,000.00	105,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	00.00	105,000.00	105,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	654,300.00	654,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	404,300.00	404,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	982700.00	982700.00	2397600.00	2397600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	982,700.00	982,700.00	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	2,397,600.00	2,397,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5700000.00	5700000.00	112200.00	84300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,700,000.00	5,700,000.00	112,200.00	84,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,700,000.00	5,700,000.00	112,200.00	84,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,159,300.00	58,159,300.00	296,687,600.00	316,304,514.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	58,159,300.00	58,159,300.00	249,293,100.00	269,265,041.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	58,159,300.00	58,159,300.00	249,293,100.00	269,265,041.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	47,394,500.00	47,039,473.00

**Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	47,394,500.00	47,039,473.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19	19	19
620001	Удирдах ажилтан	01	01	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	14	14
620003	Үйлчлэх ажилтан	04	04	04	04
631	СУРГУУЛИЙН ӨМ-НӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	145	145	145	145
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	145	145	145	145
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	19	19	19	19

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: ГЭРЭЭТ АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27